



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 05 сарын 20 өдөр

Дугаар 180

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Говь-Алтай аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, сэргээн засварлах боломжгүй болсон 15 нэрийн нийт 36,317,193.00 (гучин зургаан сая гурван зуун арван долоон мянга нэг зуун ерэн гурван) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг хичээл сургалтад сэлбэг, материалаар ашиглах зориулалтаар акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, Говь-Алтай аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батсанчир нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, хичээл сургалтад ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу Байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Акталж, данснаас хассан автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс хасуулсан тодорхойлолт, дээрх арга хэмжээний биелэлтийг 2021 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ


ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



132001419

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн
..... дугаар тогтоолын хавсралт



Говь-Алтай аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн
үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, акталж данснаас хасах хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашигла лтад орсон огноо	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)
1	Өнгөт принтер	2014	1	600,000.00	600,000.00
2	Батерей цэнэглэгч	2013	2	329,820.00	659,640.00
3	Компьютер	2011	7	1,130,000.00	7,910,000.00
4	УАЗ-469 23-46 ГАА	2002	1	6,874,200.00	6,874,200.00
5	ГАЗ-53 12-95 ГАА	1990	1	7,416,900.00	7,416,900.00
6	Авто чиргүүл	1985	1	289,440.00	289,440.00
7	Оёдлын машин	2012	32	177,600.00	5,683,200.00
8	Бялдаржуулах тоног төхөөрөмж	2002	1	1,338,230.00	1,338,230.00
9	Кантнер	2001	1	1,980,000.00	1,980,000.00
10	Проектор	2010	1	1,000,000.00	1,000,000.00
11	Ор унталгын	2006	1	351,500.00	351,500.00
12	Сервант	1981	2	14,580.00	29,160.00
13	Сурагч шар ширээ	2013	6	130,494.00	782,964.00
14	Сурагч шар сандал	2013	16	22,944.00	367,104.00
15	Хөгжим	2005	1	1,034,855.00	1,034,855.00
	Нийт дүн		74		36,317,193.00 /гучин зургаан сая гурван зуун арван долоон мянга нэг зуун ерэн гурван/